

## УЛС ТӨРИЙН НАМЫН СИСТЕМЫН СУДАЛГАА, АНГИЛАЛ

**С.МӨНХБАТ**

*МУИС. Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч  
Доктор, профессор*

**Э.БАТ-ЭРДЭНЭ**

*Улс төр судлалын тэнхимийн докторант*

**Түлхүүр үг:** Улс төрийн нам, улс төрийн намын систем, олон намын систем, намын системийн талаарх үзэл баримтлалууд, намын системийн ангилал, төлөвшилт

\* \* \*

Улс төрийн намын системийн тухай ойлголт нь улс төрийн шинжлэх ухаан дахь нам судлалын тулгуур судлагдахуун төдийгүй ардчиллын хөгжил, чанарыг илэрхийлсэн чухал нэг шалгуур үзүүлэлт юм. Учир нь олон намын системийн төлөвшилт нийгэм дэх плюрализм буюу олон ургальч үзлийн бодит илэрхийлэл, хэрэгжилтийн үр дүн байдаг гэдгийг ардчилал өндөр хөгжсөн орнуудын бодит амьдрал харуулж байна. Нөгөө талаар олон намын тогтолцоог хууль, эрх зүйн хүрээнд хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах замаар биеллээ олдог. Улс төрийн шинжлэх ухааны эрдэмтэн судлаачид ч орчин үеийн улс төрийн ардчилал нь эцсийн дүндээ нам, намын ардчиллаас ангид байх бололцоогүй юм гэдэг дээр санал нэгдэж байна<sup>1</sup>. Манай орны тухайд ч ардчилсан шилжилт, ардчиллын бэхжилтийн үйл явцад намын хөгжил, намын системийн төлөвшил онцгой үүрэг гүйцэтгэх талаар судлаачид үнэлсэн байдаг<sup>2</sup>.

Бид энэхүү өгүүлэлдээ улс төрийн намын системийг тогтолцооны чиг хандлагын үүднээс тайлбарлан үнэлэхийн зэрэгцээ намын системийн онол, үзэл баримтлал, судалгааны арга зүйн хувьсал, өөрчлөлтийг судлан дүгнэж гаргахыг эрмэлзсэн болно.

### **Нэг. Улс төрийн намын системийн тухай ойлголт, онол, үзэл баримтлал**

Улс төрийн намын системийн тухай ойлголт намын түүхэн хөгжлийн явцад бүрэлдэж, судалгааны тогтсон тайлбарлал, ангиллыг бий болгожээ. XIX зууны 30-аад оноос намыг бодлого, үйл ажиллагаа, улс төрийн системд эзлэх байр сууриар нь ангилах оролдлогыг анхлан М.Острогорский, Р.Михельс нарын томоохон эрдэмтэд хийжээ. Эдгээр судлаачид улс төрийн намыг нийгмийн бүлэг, үзэл суртал, зохион байгуулалтын хэлбэрээр нь ангилсан явдал намын системийн судалгаа хөгжих үндэс болсон байна. Түүнээс хойш XX зуунд намын систем нь улс төрийн шинжлэх ухааны нэг судлагдахуун болон хөгжиж, өөрийн бие даасан онол, үзэл баримтлалыг бий болгосон юм. Нам судлал, намын системийг судлах үйл хэрэгт В.И.Ленин, М.Дюверже, Жан Блондель, Ж.Сартори, Р. Дали, Г. Алмонд, Ж.Брайс, Р.Н.Шверценберг, Жозеф Шумпетер, Таагепера, Макку, Лааксо зэрэг судлаачид голлох үүрэг гүйцэтгэсэн.

**Морис Дюверже:** Францын Сорбоны их сургуулийн профессор тэрээр намын системийг судалж, энэ чиглэлийн судалгааг шинэ түвшинд гаргахад онцгой үүрэг гүйцэтгэсэн билээ. М.Дюверже намын системийг судлахдаа намуудын тоог үндэс болгон ангилсан. *Хоёр намын систем:* Хоёр намын тогтолцоотой улс оронд зөвхөн хоёр нам л засгийн эрхийн төлөөх гол өрсөлдөөнд оролцож, төрийн эрхийг барьж байдаг. *Олон намын систем:* Засгийн эрхийн төлөөх өрсөлдөөнд нөлөөлөх чадвартай, нарийн зохион байгуулалттай хоёр ба түүнээс олон намтай улс орныг олон намын системтэй хэмээн үзнэ.

**Роберт Даль:** Йелийн их сургуулийн (Yale university) профессор тэрээр намын системийг судлахдаа сөрөг хүчний өрсөлдөх чадварыг шалгуур болгон дараах хувилбаруудыг дэвшүүлсэн юм. *Чанга өрсөлдөгч намын систем:* Энэхүү намын системийн хувилбар нь хүчтэй сөрөг хүчний оролцоотойгоор бий болдог бөгөөд вестминистерийн улс төрийн хэв загвартай улс орнуудад түлхүү төлөвшсөн байна. *Хамтран ажиллан өрсөлдөгч намын систем:* Нэг засгийн газарт эвсэл болон орсон ч тухайн намын гишүүн нь парламентад эсрэг байр суурьтай байхыг хуулиар хамгаалсан байдал буюу улс төрийн шинжлэх ухаанд “back bancher” хэмээн нэрлэдэг намын систем. *Нэгдэн өрсөлдөгч намын систем:*

<sup>1</sup> Роберт Дали. “Ардчилал ба түүний шүүмж”, “Ардчилалын тухай”, Ларри Даймонд “Ардчиллыг хөгжүүлэхүй”, Жозеф Шумпетер, “Капитализм, социализм ба ардчилал” ..., зэрэг бүтээлд бичигдсэн байна.

<sup>2</sup> Ш.Содином, Ц.Ганболд, Ё.Довчин. “Монгол дахь ардчилах үйл явц ба сонгууль”. Политологи сэтгүүл № 297. 13 дахь тал. УБ., 2009 он

Энэ төрлийн хувилбарт ихэвчлэн хатуу гэрээний үндсэн дээр засгийн газрыг хамтран байгуулж буй хоёр намын системийн хэв загвар юм. *Чанд нэгдэгч намын систем*: Ямар нэг болзолгүйгээр хамтран ажилладаг намын системийн хэлбэр юм.

**Жан Блондель**: Францын улс төр судлаач эрдэмтэн, Европын их сургуулийн профессор тэрээр намын системийг тоон шалгуурт үндэслэн судалж дараах байдлаар ангилан авч үзсэн байна. *Хоёр намын систем*: Гол шалгуур нь хоёр нам засгийн эрхийг ээлж дараалсан байдлаар тэнцүүхэн барьж ирсэн төрт ёсны тодорхой өв уламжлал, соёлтой оронд төлөвшдөг хэмээн үзсэн байна. *Хагас хоёр намын систем*: Хоёр нам нийт иргэд сонгогчдын дийлэнхийн саналыг авч засгийн газрыг бүрдүүлэх эрхийг авсан ч хоёулаа парламентад адил хэмжээний суудалтай тохиолдолд гурав дахь хүчний оролцоог авахаас өөр аргагүй үед үүсдэг хэлбэр. *Нэг ноёлох намтай олон намын систем*: Хэдийгээр олон намын системийг хүлээн зөвшөөрч хууль, эрх зүйн хүрээнд баталгаажуулсан ч нэг нам гурваас дээш сонгуульд ялалт байгуулж, засгийн эрхийг барих үед бий болдог. *Ноёлох намгүй олон намын систем*: Тодорхой нэг нам дангаар засгийн эрхийг барьдаггүй, зөвшилцлийн улс төрийн соёл, зарчим, уламжлалд тулгуурлан парламентад суудал авсан намууд гүйцэтгэх засаглалд оролцох хэлбэр юм.

**Жавонни Сартори**: Италийн улс төр судлаач, Колумбийн их сургуулийн профессор тэрээр намын системийг судлахдаа намуудын тоо, тэдгээрийн үзэл суртлын алслалтыг шалгуур болгон ангилсан. Нэг намын ноёрхолын тухай нэр томъёог 1950-иад оны үед анх оруулж ирэн, энэ үндсэн дээр ноёрхогч намын систем, хязгаарлагдмал намын системийн үзэл санааг гаргажээ. Жавонни Сарторийн судалгаа, үзэл баримтлал, хандлагаар намын тогтолцооны ноёрхогч хэв маяг буюу нэг намын ноёрхол, намын системийн зонхилгогч хэв маяг буюу хоёр намын систем, намын системийн хязгаарлагдмал хэв маяг буюу хоёр нам зонхилсон дагавар нэг намын систем, намын системийн туйлширсан хэв маяг буюу хэт олон намын систем (энэ үед олон намын туйл болж төрд аюул учирна хэмээн үзсэн), намын системийн плюралист хэв маяг буюу олон намын систем, намын системийн сарнисан хэв маяг буюу тодорхой хэлбэрт баригддаггүй хувилбарууд байна хэмээн үзжээ.

Дээрх судлаачдын дэвшүүлсэн онол, үзэл баримтлал судалгааны үр дүнд намын системийн тухай орчин үеийн ойлголт, үзэл баримтлал бүрэлдсэн юм. Намын системийн талаарх судлаачдын баримталж буй байр суурийн үүднээс асуудалд хандаж авч үзвэл “Намын систем гэдэг нь засгийн эрх болон түүнийг хэрэгжүүлэхийн төлөө тэмцэж буй намуудын харилцан нөлөөлөл, өрсөлдөөний механизм юм” гэж тодорхойлж болохоор байгаа юм.

Үүнийг улам бүр тодорхой болгох үндэс нь намын системийн мөн чанарыг тайлбарлах, түүний гүнд нэвтрэх явдал мөн. Улс төрийн намын системд нөлөөлдөг хүчин зүйлсийг улс төрийн шинжлэх ухаанд *дотоод* болон *гадаад* хэмээн ангилдаг. Дотоод хүчин зүйлсийг улс төрийн намын төлөвшилтэй холбоотой авч үзэж байгаа бол гадаад хүчин зүйлсийг улс төр, эдийн засгийн бусад ойлголтуудтай холбоотойгоор авч үздэг болсон байна. Тухайлбал, төрийн удирдлагын хэлбэр, сонгуулийн систем, ардчиллын хөгжил, эдийн засгийн тогтолцоо зэрэг голлох нөлөөг үзүүлнэ хэмээн үзэж байна. Улс төрийн намын системд нөлөөлөгч дотоод хүчин зүйлст тухайн улсад үйл ажиллагаа явуулж байгаа намын тоо, зонхилох нам, эвсэл байгаа эсэх, намуудын хоорондын өрсөлдөх чадварын түвшин зэрэг ойлголтууд багтана.

Улс төрийн шинжлэх ухаанд намын системийг дараах байдлаар ангилж буй хандлага нийтлэг байна. Үүнд:

- а. **Нэг намын тогтолцоо**: Нэг намын тогтолцооны хэв маягт төрийн удирдлагын хэлбэр голлох нөлөөг үзүүлдэг. Өөрөөр хэлбэл коммунист үзэл баримтлалд суурилсан авторитар, тоталитар дэглэм бүхий улс оронд ихэвчлэн төлөвшдөг байна. Энэ чиглэлийн томоохон жишээ нь хүйтэн дайны үеийн үзэл суртлын зөрчлөөс үүдсэн хуваагдал юм. Орчин үед нэг намын тогтолцоотой улс оронд намын систем гэсэн ойлголт байхгүй гэсэн хандлага ч түгээмэл байсаар байна. Учир нь тоталитар, авторитар дэглэмд нэг нам дангаар ноёлон бусад намууд аядуу үйл ажиллагаа явуулах боломжгүйг түүхээс бид мэдэх билээ. Нөгөө талаас ноёлогч нам нь төрийн нэг хэсэг болж, өөрийн үзэл баримтлал, үнэт зүйлсийг хатуу тулгах замаар үйл ажиллагаагаа явуулж байдаг нь бусад намуудын оршин тогтнох боломжийг хумиж хязгаарладаг байна.
- б. **Хоёр намын систем**: Хоёр намын систем нь нэг талаас вестминистерийн загварын тусгал, нөлөө юм. Өөрөөр хэлбэл вестминистерийн төрийн загварын тулгуур зарчим нь хоёр намын системд суурилж, намын системийн энэхүү хувилбарыг дэмжсэн улс төрийн соёл, зарчмыг төлөвшүүлсэн байдаг. Хоёр намын системийг дотор нь сонгодог загвар буюу иргэд сонгогчдын 90 хувийн саналыг хоёр нам авдаг тогтолцоо, үндсэн хоёр намтай ч засгийн эрхийн төлөөх өрсөлдөөнд нөлөө үзүүлэх чадвартай нэмэлт намууд (2+1) гэсэн хоёр хувилбарт ангилан судалж байна.
- в. **Олон намын систем**: Засгийн эрхэнд нөлөөлөх чадвар бүхий хоёроос дээш намуудын үйл ажиллагааны үр дүнд олон намын систем төлөвшдөг. Энэхүү олон намын систем төлөвшин бий болоход боннын

загвар голлох үүргийг гүйцэтгэсэн юм. Олон намын системийг дотор нь системийн эсрэг намууд буюу тухайн улсынхаа нийгэм-эдийн засгийн байгуулалд шүүмжлэлтэй ханддаг, сөрөг хүчний шинжтэй үйл ажиллагаа явуулдаг намууд, мөн засгийн эрхийн төлөө 3-5 нам нарийн зохион байгуулалтаар өрсөлдөж, ихэвчлэн эвслийн засгийн газар байгуулж, сөрөг хүчингүйгээр үйл ажиллагаа явуулдаг аядуу систем хэмээн хоёр хувилбарт хуваан авч үзэж байна.

#### **Хоёр. Улс төрийн намын системийн судалгааны хөгжил, чиг хандлага**

Улс төрийн шинжлэх ухаанд XIX зууны эхэн үеэс нам судлалын судалгааг шинжлэх ухааны түвшинд нарийвчлан судалж эхэлсэнээр бие даасан томоохон салбар болон хөгжих үндэс тавигдсан юм. Улс төрийн нам судлалын судалгаа нарийвчлагдан гүнзгийрч тодорхой түвшинд хүрсэн XIX зууны сүүл XX зууны эхэн үед намын системийн судалгааны үндэс тавигджээ. Орчин үеийн улс төрийн шинжлэх ухаанд намын системийг судлахдаа тоон болон чанарын хэмжүүрт авч үзэх хандлага нийтлэг ажиглагдаж байна. Тоон хэмжүүрийн тухайд орчин үеийн ихэнх судлаачид энэхүү хэмжүүрийг ашиглан нэг намын, хоёр намын, олон намын зэрэг хувилбаруудыг боловсруулан судалгаандаа ашигласаар байна. Харин намын системийг судлах чанарын хэмжүүрийн тухайд намуудын үзэл баримтлалд тулгуурлан зүүний болон барууны, радикал болон аядуу зэргээр улс төрийн чиг баримжаанд тулгуурлан системчлэх оролдлогыг хийж ирсэн байна. Улс төрийн намын системийн судалгааны хөгжлийн явцад дараах гурван хандлага голлох нөлөөг үзүүлсэн. Үүнд:

**Дювержийн хууль:** Улс төрийн намын системийг судлах энэхүү хандлагыг Францын судлаач Морис Дюверже 1954 онд боловсруулсан. Гол агуулга нь сонгуулийн тогтолцоо намын систем хоёр өөр хоорондоо шууд хамааралтай байдгийг нотолсонд оршино. Өөрөөр хэлвэл намын системд нөлөө үзүүлэх гол хүчин зүйл бол сонгуулийн тогтолцоо юм хэмээн үзжээ. Түүний дүгнэснээр сонгуулийн олонхийн систем (мажоритар) нь хоёр намын системийг дэмжиж байдаг бол хувь тэнцүүлэх систем (пропорциональ) нь олон намын тогтолцоог дэмжиж байдаг аж. Учир нь хувь тэнцүүлэх буюу сонгуулийн пропорциональ систем нь томсгосон тойрогт ихэвчлэн хэрэглэгддэг, жижиг намууд парламентат суудал эзлэх боломжийг нээж өгдөг. Энэхүү хандлага нь намын системийг судлах институциональ хандлагын суурь болсон хэмээн судлаачид үнэлдэг юм. Тэрээр олон намын тогтолцоо болон парламентат ёсны төлөвшлийг бүх нийтийн сонгуулийн эрхтэй амин шүтэлцээтэй холбоотой авч үзсэн юм. Харин дийлэнх олонхийн систем нь тойрогт дэвшиж буй нэр дэвшигчдийн өрсөлдөөнд суурилдаг учир том намуудад өгөөжтэй байдаг гэсэн дүгнэлтэд үндэслэж зонхилох хоёр намын системийг төлөвшүүлдэг гэж үзжээ.

**Липсет ба Роканнын европын намуудын системийн тогтворжилтын судалгаа:** Америкийн судлаач Сеймор Липсет, Роканин нар XX зууны сүүлийн хагас дахь европын намуудын системийн төлөвшилд нөлөөлсөн хүчин зүйлийн судалгааг хийсэн байна. Дээрх судлаачид европын улс орнуудын намын системийн үзэл санаанд өнгөрсөн зууны 20-иод оны үед тогтсон нийгмийн нэгдсэн бүтцүүд голлох нөлөөг үзүүлсэн хэмээн тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл намын системд тодорхой бүлгүүдийн эрх ашиг чухал нөлөөг үзүүлдэг болохыг тогтоожээ. Тухайлбал Швейцар улсад Христийн ардчилсан намыг чин сүсэгтэй католикчууд л дэмждэг бол Социаль демократ болон Радикал намуудыг сүм хийдэд хааяа эсвэл огт очдоггүй католик болон протестантууд л дэмждэг нь олон жилийн сонгуулийн үр дүнгээр давтагдсан байна. Үүнийг нэг талаас нь дүгнэвэл шашин, соёлоороо хуваагдсан явцгүй үзэгдэл, жишиг хэмээн үзэж болох ч иргэд өөрийн чиг хандлага, үнэт зүйл дээр тулгуурлан саналаа өгнө гэдэг нь итгэл үнэмшил дээр суурилсан улс төрийн оролцоо, нийгэмшил бий болох үндэс юм хэмээн дүгнэсэн байдаг<sup>3</sup>.

**Р.Таагепера, М.Шугарт, Лааксо нарын үзэл баримтлал:** Намын системийн төлөвшлийг “намуудын үр ашигтай байдал” хэмээх ойлголтонд тулгуурлан тайлбарлаж, намуудын үр ашигтай байдлыг судлах хэрэгтэй хэмээн үзсэн юм. Энэхүү үзэл баримтлалын үндсэн аргачлал нь парламентад суудал бүхий намуудын хувь хэмжээг тогтоох үндсэн дээр намын системийг судлахад чиглэгдсэн байна. Намуудын үр ашигтай байдал хэмээх ойлголтонд дараах хүчин зүйлсийг хамааруулан авч үзжээ. Үүнд:

- Намуудын парламентад авсан суудлын тоо
- Хууль тогтоох үйд ажиллагаанд намууд оролцох оролцооны түвшин
- Сонгуульд оролцсон намуудаас парламентад суудал авсан намуудын тоо
- Шийдвэр гаргахад бодитой оролцон нөлөөлөх намын нөлөө, эрх мэдэл, оролцооны шинж байдал
- Парламентын сонгууль болон ерөнхийлөгчийн сонгуулийн уялдаа
- Парламентад суудалтай намуудын тоо болон нэрсийн жагсаалтаар сонгогдсон тоон үзүүлэлтийн харьцуулал зэргийг хамруулан авч үзсэн байна.

Энэхүү үзэл санаагаа дээрх судлаачид тайлбарлахдаа “бүх байгаа намуудын тоог бус, харин намуудын үр ашигтай тоог ашиглахын давуу тал нь ач холбогдол бүхий намуудыг ач холбогдол багатай намуудаас ялгаж ойлгох оновчтой арга юм<sup>4</sup>” хэмээн тэмдэглэсэн байна.

<sup>3</sup> Seymour Martin Lipset. "Political man: The social bases of politics". Part II. Voting in Western Democracies. Chapter VI. Elections: Who Votes and Who Doesn't?. United States, 1960

<sup>4</sup> Г.Чулуунбаатар, Б.Даш-Ёндон. "Монголын нийгмийн өөрчлөлт". 275-276 дахь тал. УБ., 2013 он

**Гурав. Монгол дахь улс төрийн намын системийн хөгжил, төлөвшил**

Монгол Улсад анхлан 1921 онд нам байгуулагдсанаас хойш 70 орчим жилийн хугацаанд нэг намын системд оршин тогтносон нь улс төрийн плюрализмын суурь буюу олон намын системд шилжихэд тодорхой сорилт, бэрхшээлүүдийг дагуулсан юм. Эдүгээгийн монголын нийгэм, улс төрийн тогтолцоо, намын системийн хөгжил, төлөвшилтийг судлаачид олон янзаар тайлбарлаж буй нь шилжилтийн үеийн болон, шилжилтийн дараах нийгмийг судлах онол, арга зүй нэгдмэл байдлаар бий болоогүй байгааг илтгэж байгаа билээ. Учир нь монголын улс төрийн намын систем харьцангуй хожуу өөрийн дүр төрхөө олж буйг судлаачид тэмдэглэж байна.

Ардчилсан үнэт зүйлс, үйл явцад шилжих гарааны нөхцлөөс өнөөг хүртэлх нийгэм, улс төрийн хөгжлийн нэг үр дүн болсон намын системийн төлөвшилтийг зарим судлаачид цаг хугацааны шалгуураар үнэлэн доорх үечлэлд оруулан авч үзсэн байна. Үүнд:

- Ардчилалын үйл явцад шилжих шилжилтийн гарааны эхэн үеийн намын систем (1990-1990 оны дунд үе).
- Төлөвшилтийн үндэс, тулгуураа олсон нягтрал, бэхжилтийн үеийн намын систем (1996 оноос өдгөөг хүртэлх үе).
- Намын системийн жигдэрч төлөвшсөн хэлбэр, хожим үйлчлэх намын системийн хэлбэр<sup>5</sup> ..., хэмээн гурав хуваан авч үзсэн байна.

Өдгөөгийн Монголын намын системийн төлөвшлийг эрдэмтэн судлаачдын олонхи нь хоёр намын систем хэмээн дүгнэдэг бол тодорхой цөөн тооны судлаачид олон намын систем, хоёр хагас намын систем, нэг намын ноёрхол бүхий дагуул намуудын систем гэх зэргээр ангилж дүгнэсэн байдаг. Хоёр голлох улс төрийн нам засгийн эрхийг ээлжлэн буюу хамтран барьж ирсэн сүүлийн 27 жилийн улс төрийн практик Монгол улсыг хоёр намын системтэй гэсэн дүгнэлтэд олонхи судлаачдыг хүргэдэг бол харин зонхилох хоёр намаас гадна гуравдагч улс төрийн хүчин парламентад тогтмол шахуу суудал авч ирсэн нь олон намын системтэй гэсэн дүгнэлтийг (тоон үзүүлэлт талаасаа) ч хийхэд хүргэж буйг онцлон тэмдэглэх нь зүйтэй юм.

Орчин үеийн улс төрийн шинжлэх ухаанд бүх нийтийн сонгох эрх болон сонгуулийн үйл явцыг намын системийн төлөвшилтэй холбоотойгоор тайлбарласан онол, хандлагууд түгээмэл болсон байна. Монгол улс олон намын системд шилжин орсноос хойш нийт найман (1990 оны АИХ-ын сонгуулийн оролцуулаад) удаагийн парламентын сонгууль явуулжээ. Эдгээр сонгуулийн үр дүнгээр бий болсон парламент дахь хүчний харьцаа намын системийг тодорхойлох чухал үндэслэл мөн гэдэгт онол, арга зүйн хувьд ач холбогдол өгөх учиртай. Энэ үүднээс асуудалд хандвал 1990 оноос өнөөг хүртэлх намын системийн хөгжлийг дараах байдлаар ангилж болох юм. Үүнд,

- 1990-1992 он. Өөрчлөлтийн гарааны эхэн үеийн намын систем.
- 1992-1996 он. Зонхилогч намын систем.
- 1996-2000 он. Хоёр намын систем.
- 2000-2004 он. Намын системийн “нэг нам ба бусад” хэв маяг.
- 2004-2008 он. Нэг нам зонхилсон хоёр хагас намын систем.
- 2008-2012 он. Хоёр намын зөвшлийн систем.
- 2012-2016 он. Олон намын систем оршин тогтносон хэмээн үзэж болно.

Хууль тогтоох байгууллагын сонгуулийн үр дүн, сонгуулийн тогтолцооноос хамаарсан намын системийн хэв маягийг харьцуулан харуулья.

*Хүснэгт 1.*

**Намын тогтолцооны хэв маяг ба сонгуулийн тогтолцооны харилцан хамаарал<sup>6</sup>**

№	Намын системийн хэв маяг	Хугацаа	Сонгуулийн хэлбэр
1	Шилжилтийн хэв маяг (Сул хоёр намын тогтолцоо)	1990-1992	Холимог
2	Зонхилогч намын тогтолцоо	1992-1996	Плюраль, Олон мандаттай мажоритар
3	Хоёр намын тогтолцоо	1996-2000	Плюраль, Нэг мандаттай мажоритар
4	“Нэг нам ба бусад” буюу нэг нам+дагуул намын тогтолцоо	2000-2004	Нэг мандаттай мажоритар
5	Нэг нам ба зонхилсон хоёр хагас намын тогтолцоо	2004-2008	Олон мандаттай мажоритар

<sup>5</sup> Г.Чулуунбаатар, Б.Даш-Ёндон. “Монголын нийгмийн өөрчлөлт”. 267-268 дахь тал. УБ., 2013 он

<sup>6</sup> Г.Чулуунбаатар, Б.Даш-Ёндон. “Монголын нийгмийн өөрчлөлт”. 268 дахь тал. УБ., 2013 он

6	Хоёр намын зөвшлийн буюу хоёр намын тогтолцоо	2008-2012	Олон мандаттай мажоритар
7	Олон намын тогтолцоо	2012-2016	Олон мандаттай холимог хэлбэр

### Дүгнэлт

Монгол олон намын систем бодит байдал болж буй хэдий ч нийгмийн хөгжил, өөрчлөлт, улс төрийн нөхцөл байдалтай уялдуулан авч хэрэгжүүлэх, шийдвэрлэх тулгамдсан асуудлууд байсаар байна. Юуны урьд улс төрийн системийн хүрээнд ардчиллын бэхжилт, чанаржилтын үйл явцтай холбон шинжилж нарийвчлан судлах шаардлага зүй ёсоор тулгарч байна. Үүнд,

- Монголын улс төрийн орчны хөгжил сул, иргэдийн улс төрийн боловсрол, ухамсар, соёл доогуур байгаа нь асуудлын үндэс болж сонгуульт ардчиллаар дамжин бэхждэг намын системийн төлөвшилд сөрөг нөлөөг үзүүлсээр байна. Нөгөө талаар намуудын шинжлэх ухаанч байдал, бодлогын өрсөлдөөн сул байгаатай холбогдон иргэн төрийг холбогч шинжээ намууд улам бүр алдах эрсдэлтэй нүүр тулж байна. Иргэдийн улс төрийн соёл, боловсролын түвшин ч үүнд шууд хамаатай.
- Намуудын төлөвшил сул байгаагаас үүдэн намуудыг үнэлэх олон түмний үнэлэмж буурах, итгэл алдрах байдал нийтлэг болж намуудын легитимт шинж алдагдаж байна. Сүүлийн жилүүдэд хийгдсэн судалгаануудаас үзэхэд иргэдийн зүгээс хамгийн ихээр итгэл алдарч байгаа институцийн эхэнд улс төрийн нам орж байгаа нь үүний нотолгоо юм.
- Улс төрийн намын системийг төлөвшүүлэх эрх зүйн орчин сул байна. Намын төлөвшлийг хангах эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай байна.
- Парламентын сонгуулийн өмнөх болон дараах улс төрийн нөхцөл байдал нь намын системийн төлөвшилд ямар нэг байдлаар нөлөөлсөөр байна. Энэхүү үзэгдэл нь монголд тодорхой намын системийн хэв маяг, тогтолцооны загвар бий болоогүйг илтгэж байгаа үзүүлэлт юм. Тиймээс сонгуулийн хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох замаар, сонгуулийн тогтолцооны оновчтой хувилбарыг сонгож хэвшүүлэх явдал юу юунаас чухал байна.

**Abstract:** A party system is a concept in comparative political science concerning the system of government by political parties in a democratic country. The idea is that political parties have basic similarities: they control the government, have a stable base of mass popular support, and create internal mechanisms for controlling funding, information and nominations. This article contributes to the study conception and classification of party system by political scientists and scholars. The concept was originated by European scholars studying the United States, especially James Bryce and Moisey Ostrogorsky, and has been expanded to cover other democracies. Giovanni Sartori devised the most widely used classification method for party systems.

The party system in Mongolia has been characterized by instability and fragmentation since the democracy in 1990. In part this instability is rooted in the legal framework regulating political parties as organizations and the factions that parties performs in a democracy. The article outlines the formation and development that analyzed political party system in Mongolia since 1990.

### НОМ ЗҮЙ

1. Аренд Лийпхарт. Ардчиллын хэв загвар. УБ., 2008 он
2. Д.Болд-Эрдэнэ. Монголын улс төрийн нам, намын системийн төлөвшил. УБ., 2008
3. Морис Дюверже. Улс төрийн байгууламж, Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2007
4. Монголын ардчиллын төлөвшил. ШУА. Хамтын бүтээл. УБ., 2011
5. Г.Чулуунбаатар, Б.Даш-Ёндон. Монголын нийгмийн өөрчлөлт. УБ., 2013
6. Г.Чулуунбаатар. XX, XXI зууны зааг үеийн Монголын нийгэм, иргэншлийн өөрчлөлт. УБ., 2008
7. Монголын нийгмийн өөрчлөлт. ШУА. Хамтын бүтээл. УБ., 2013
8. Улс төрийн шинжлэх ухаан. МУИС. Хамтын бүтээл. УБ., 2010
9. Ардчилал ба улс төрийн нам. Онол, практикийн бага хурлын эмхэтгэл. УБ., 2009
10. С.Е.Заславский. Основы теории политических партий. М., 2007
11. Sartori G. Parties and party systems: A framework to Analysis. Cambridge. 1976
12. Jean Blondel. Voters, parties and leaders: the social fabric of British politics. London., 1963
13. William Goodman. The party system in America. USA. 1980
14. Политологи сэтгүүл. МУИС № 297. УБ., 2009 он
15. Философи, эрх зүйн судлал сэтгүүл. ШУА. XXVIII боть. УБ., 2013
16. Монгол Улсын Үндсэн хууль, УБ., 1992
17. Улс төрийн намын тухай хууль, УБ., 2005
18. Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, УБ., 2005